



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2025 он



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН
(жилийн эцсийн байдлаар)**

2026.01.09

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны Төмөр замын тээврийн бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Зам, тээврийн яамны Төмөр замын тээврийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 66.8%-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
9	2	-	7	-	45.6

2.2. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	



6	1	-	5	-	41.7%
---	---	---	---	---	-------

2.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
19	7	11	1	-	71.0%

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
22	13	7	1	1	-	78.6

2.5. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
59	48	1	9	-	1	83.6

2.6. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Үүнээс /хувиар/					Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
40	33	-	5	-	2	86.8

2.7. Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт:

Аймаг, нийслэл	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь					Үнэлгээний дундаж (хувь)
		Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
		100%	50%	0%			
Нийслэл	3	2	-	-	-	1	100.0
Говьсүмбэр	3	2	1	-	-	-	83.3
Дархан-Уул	3	2	1	-	-	-	83.3
Дорноговь	4	2	2	-	-	-	75.0



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Дорнод	3	3	-	-	-	-	100
Завхан	3	1	2	-	-	-	66.7
Орхон	3	2	-	-	-	1	100.0
Өмнөговь	5	4	1	-	-	-	90.0
Сэлэнгэ	4	4	-	-	-	-	100.0
Төв	5	-	5	-	-	-	50.0
Ховд	2	-	-	-	-	2	-
Хэнтий	5	3	-	-	-	2	100
Нийт	43	25	12	-	-	6	83.8

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

ТЗТБЗГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. /1.5, 5.4, 5.5/

Хэрэгжилтийн байдал:

1) ЗТЯ-ны Төмөр замын тээврийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 66.8%-тай байна.

2) “Монголиан транс лайн” ХХК ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логикийн төв төслийг эхлүүлэх, “Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэх, “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорыг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд Сүхбаатар – Хөшгийн хөндий-Замын-Үүд” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах, “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх ТЭЗҮ-ийг баталгаажуулах зэрэг ажлууд хангалтгүй хэрэгжилттэй хэвээр байна.

3) Засгийн газрын 2025 оны 73 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газар байгуулагдсантай холбогдуулан Төмөр замын тээврийн бодлого, зохицуулалтын газрын зарим чиг үүрэг шилжсэн. Үүнтэй холбогдуулан тус газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн батлах шаардлага гарч, шинэчилсэн төлөвлөгөөг баталсан. Шинэчилсэн төлөвлөгөөнд туссан нийт 19 арга хэмжээний хэрэгжилт 71.0 хувьтай байна. Үүнээс 68.4 хувь нь зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн буюу хэрэгжилтийн шатандаа байгаа бол 31.6 хувь нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

4) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

№	Арга хэмжээ	Зорилтот түвшин	Дундаж хувь
---	-------------	-----------------	-------------



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

1	Зорилт 1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.	Төмөр замаар 50,0 сая.тн /ачааны хэмжээ 47.5 сая.тн/-оос доошгүй ачаа, 2.5 сая зорчигч тээвэрлэнэ.	86.7
2	Зорилт 2. Төмөр замын сүлжээг өргөтгөж, 3200 км орчим төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.	Төслийн 1 түншлэгчтэй гэрээ байгуулна, 3 төслийн ТЭЗҮ-д бүрэн шинжилгээ хийнэ, 2 төслийн ТЭЗҮ-ийг ШУТЗ-өөр хэлэлцүүлнэ.	40.0
3	Зорилт 3. Төмөр замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангана.	Замын их засварыг хийж дуусгана.	65.0
4	Зорилт 4. Төрийн үйлчилгээг ил тод нээлттэй, түргэн шуурхай болгож цахимжуулж. чанар, хүртээмжийг сайжруулна.	Төмөр замын тээврийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй, шуурхай оновчтой байдлаар зохион байгуулж цахимжуулна.	95.0
5	Зорилт. Төмөр зам, усан зам, далайн тээврийн салбарын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Бодлогын баримт бичиг-1, дүрэм-3, журам-10, стандарт-13, аргачлал-1, конвенц төсөл 2-ыг тус тус батлуулна.	61.4

5) Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн уналтаас үүдэн нүүрс биржээр арилжаалагдаагүй, мөн хүлээн авагч талууд нүүрс хүлээн авахаас түр хугацаанд татгалзсан нь төмөр замаар ачаа тээврийн хэмжээ нэмэгдүүлэх зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлжээ. Мөн төмөр замын зорчигч тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор төлөвлөсөн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлсэн хэдий ч хэрэгжилтийн явцад техник технологи, вагоны парк шинэчлэл зэрэг хийгдээгүйгээс төлөвлөсөн зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүн бүрэн хэмжээнд хүрч чадаагүй байна.

6) Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ, зорилтуудын хэрэгжилтийг хангахад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдээгүйгээс шалтгаалан төлөвлөсөн ажлуудыг бодитой хэрэгжүүлэх боломж хязгаарлагдаж, улмаар хэрэгжилтийн түвшин хангалтгүй хэвээр үнэлэгдсэн.

7) ТЗТБЗГ-ын 2025 оны III улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн 7 зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

1. “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорыг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд Сүхбаатар – Хөшгийн хөндий-Замын-Үүд чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах;

2. “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх ТЭЗҮ-ийг баталгаажуулах;

3. “Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэх;

4. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логистикийн төв төслийг эхлүүлэх;



8) Цаашид эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан, уг төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт, материалын хамт бүрэн тайлагнадаг тогтолцоог хэвшүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах нь зүйтэй байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 30-59 хувийн хэрэгжилттэй 7, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан 30-59 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээний биелэлтийг зорилтот түвшинд хүргэн ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг улирал тутам шинэчлэн ирүүлж хэвших;

2. “Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх яриа хэлэлцээрт хэлэлцээрт суурь судалгаа яаралтай хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

3. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логистикийн төв төслийг эхлүүлэх ажлын хүрээнд холбогдох компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэж, төслийн хөрөнгө оруулалтын асуудлыг шуурхай шийдвэрлэх;

4. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээрийг шинэчлэх

5. Хөнгөн галт тэрэгний шугам (LRT) төслийн заасан чиглэлийн 106.9 км урттай хөнгөн галт тэрэгний шугамын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;

6. Хөнгөн галт тэрэгний шугам (LRT) төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн чиглэлийн шугамын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, холбогдох шийдвэр гаргах үндэслэлийг бүрдүүлэх;

7. Хууль тотоомж, тогтоол шийдвэр болон Зам, тээврийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрэмд нийцүүлэн алдаагүй ирүүлж хэвших;

8. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан, уг төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт, материалын хамт бүрэн тайлагнадаг тогтолцоог хэвшүүлэх;

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**ЗТЯ-НЫ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

(жилийн эцсийн байдлаар)

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	9	9	45.6	20
2	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	6	6	41.7	20
3	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	19	19	71.0	20
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	20	21	78.6	20
5	Сайдын тушаалын хэрэгжилт	59	58	83.6	10
6	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	40	38	86.8	10
7	Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт	43	37	92.4	10
Нийт		196	188	66.8	